Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 1-ний өдрийн 9 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН “ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд болон анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дэргэд нийт 41 Ёс зүйн дэд хорооны 161 шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилтан дарга, гишүүдээр ажиллаж байна.

Ёс зүйн дэд хороод нь 2025 оны бүтэн жилийн байдлаар иргэд, хэргийн оролцогч, шүүгч, шүүхийн захиргааны албан хаагч нарын гаргасан гомдол мэдээллийн дагуу 80 гомдолд хяналт, шалгах ажиллагаа хийсэн. Энэхүү гомдлын шийдвэрлэлт болон ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар мэдээг Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтад дэлгэрэнгүй оруулсан болно.


Ёс зүйн дэд хорооны дүгнэлтэд үндэслэн эрх бүхий албан тушаалтны хариуцлага ногдуулсан тушаалд гомдол гарган Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан 3 нэхэмжлэлээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа 1, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 2 байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Хөтөлбөрийн хүрээнд 41 Ёс зүйн дэд хороод дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

1. Иргэд олон нийт, шүүхийн захиргааны ажилтныг мэдээллээр хангах зорилгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ болон төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарын авлага, брошур, видео контент 11 ёс зүйн дэд хороо зохион байгуулсан байна.



[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2. Шүүхийн захиргааны ажилтан болон шүүхийн Тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хорооны дарга гишүүд нарт зориулсан нэгдсэн сургалт нийт 95 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын агуулгад:

-Төрийн албан хаагч ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөх,

- зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,

- хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх,

- албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх,

- албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх,

- байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх,


- багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах гэх мэт агуулгын хүрээнд зохион байгуулсан.


Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.3.4-т заасан чиг үүргийн хүрээнд ёс зүйн сургалт зохион байгууллаа. Сургалтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, нийслэлийн шүүхүүдийн Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд танхимаар, орон нутгийн шүүхийн Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын дарга, гишүүд цахимаар оролцлоо. Удирдлагын академийн Хүний нөөцийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Ж.Алтайбаатар “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Авлигатай тэмцэх газрын ахлах ажилтан, комиссар Г.Балдандорж “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр мэдээлэл хийв.






3. 22 Ёс зүйн дэд хороод нөлөөллийн аян 1-3 сарын хугацаатай зохион байгуулж, хамт олны уур амьсгалыг эерэг, нэгдмэл болгох, харилцааны таатай уур амьсгалыг бүрдүүлэх зорилго бүхий арга хэмжээ зохион байгуулсан байна.





4. 7 Ёс зүйн дэд хороо Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлэх судалгаа хийсэн байна. Судалгааны үр дүнд тулгуурлан ганцаарчилсан уулзалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил, шийдвэл зохих асуудлыг эрх бүхий албан тушаалтанд зөвлөмж хэлбэрээр хүргүүлэх ажиллагаа хийлээ. Тухайлбал: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ёс зүйн дэд хорооноос анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороодод нийтлэг гаргаж байгаа зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр. Тасганы овоо,
5 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7710-4845, Факс: (976) 7000 7721,
Цахим шуудан: contact@judicouncil.mn,
Цахим хуудас: www.judicouncil.mn

2025 10 13 № 04/1610
танай _____-ны №_____-т

АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНД


Зөвлөмж хүргүүлэх тухай

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ёс зүйн дэд хороонд шүүхийн захиргааны байгууллагын албан хаагчдын ёс зүйтэй холбоотой 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийхэд дараах ёс зүйн зөрчлүүд нийтлаг тогтоогдсон:

- Удирдан зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар хориглосон ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт хүчирхийллийн шинжтэй үйлдэл үзүүлдэг;
- Албан харилцаанд нүүрний хувирал, биеийн хэлэмж, үг хэллэг, бусад байдлаар бусдыг үл тоомсорлох, тохуурхан дооглогнох, доромжлох зэрэг харилцаа, хандлага гаргадаг, зүй бус үг хэллэг хэрэглэдэг;
- Удирдах, удирдуулах зарчмыг бариматлаг, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас батлагдсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг цаг тухайд нь хэрэгжүүлдэггүй;
- Ажилтны эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд хүндэтгэлгүй хандаг;
- Албан хаагчийг ажил үүргээ гүйцэтгэхэд хууль бусаар нөлөөлөх, саад учруулах, кондлөнгөөс оролцдог;
- Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигладаг;
- Хэлбэрийн шаардлага хангалгүй дүгнэлт гаргадаг;
- Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнгийн тэрээр гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан бодитоор үнэлдэггүй;
- Ажилтны гаргасан алдаа зөрчилд тухай бүр тохирох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авдаггүй.

Түүнчлэн шүүхийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид нь аливаа ёс зүйн болон сахилгын шинжтэй зөрчлийн талаар нуун дарагдуулах, өөгшүүлэх, арга хэмжээ авахгүй байх, мэдсэн ч мэдээгүй мэт өнгөрөөж байгаа нь шүүхийн байгууллагад ёс зүй, сахилгын зөрчил давамжрах, хэвийн үзэгдэл болох, хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдалд хүргэх, шүүхэд итгэх олон нийтийн

0152504072728



итгэлийг бууруулах, хууль тогтоомж хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлийг дагуулж байгааг онцгой анхаарах шаардлагатай байна.

Дээр дурдсан зөрчлүүд нь төрийн албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлээгүйгээс үүдэлтэй гэж үзэхээр байна.

Иймд Төрийн албан хаагчийн ёс тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т заасны дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж байх; Аливаа гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй гомдлыг нүүн дарагдуулах нь өөрөө тухайн хэрэг, зөрчлийн холбогдогч болох эрсдэлтэйг анхаарах;

2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г тухайн байгууллагад сурталчлан таниулах, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх талаар сургалт зохион байгуулах;

3.Ёс зүйн дэд хороо тухайн жилийн ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.Тухайн ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт, хууль зүйн үндэслэлийн талаар дүн шинжилгээ хийж, шаалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээг тухайн шүүх, шүүхийн Тамгын газрын нийт ажилтнуудын хуралдаанд танилцуулж мэдээллээр хангаж хэвших;

5.Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, төрийн албанд анх томилогдсон албан хаагчид ёс зүйн чиглүүлэх сургалтыг зохион байгуулах;

6.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага бий болгоход чиглэсэн нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх;

7.Ёс зүйн зөрчим, хэм хэмжээ, шаардлагыг ойлгомжтой хэлбэрээр ангилан тэрлэсүүлсэн ёс зүйн гарын авлага, зөвлөмж, заавар боловсруулан албан хаагчдыг мэдээллээр хангах;

8.Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасны дагуу ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг хэлбэрийн шаардлага хангуулах зэрэг болно.

Хувийг: Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүхийн Тамгын газрын дарга нарт.

ЁС ЗҮЙН ДЭДХОРООНЫ ДАРГА Д.МӨНХБАТ

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга болон шүүхийн Тамгын газрын дарга өөрийн Ёс зүйн дэд хорооны ёс зүйн зөрчил гаргасан гэсэн дүгнэлтэд үндэслэн хариуцлагын арга хэмжээ авсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудастаа байршуулсан.
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн томилох эрх бүхий албан тушаалтан 7, үлдсэн 34 Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааны төсөв болон урамшуулал огт шийдэгдээгүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Шүүхийн хэмжээн дэх 41 Ёс зүйн дэд хороод нь 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө батлуулан, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа идэвх санаачилгатайгаар явуулж байна. Үүнд:

- ✓ Сургалт, хэлэлцүүлэг 95 удаа
- ✓ Гарын авлага, брошур, видео контент бэлтгэсэн 11 Ёс зүйн дэд хороо
- ✓ Нөлөөллийн аян 1-3 сарын хугацаатай зохион байгуулсан 22 Ёс зүйн дэд хороо
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлэх судалгаа хийсэн 7 Ёс зүйн дэд хороо
- ✓ Нийт 80 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
- Ёс зүйн зөвлөлд ирсэн гомдлыг зохих хууль, журмын дагуу хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэдэг болсон. - Ёс зүйн дэд хорооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь албан хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэг, сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлж, байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд бодит нөлөө үзүүлсэн. - Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал бэхжиж, үлгэр жишээ хандлага ажлын байранд төлөвшсөн. - Хууль, дүрэм, журамд нийцсэн сахилга хариуцлагын соёл төлөвшиж, зөрчил давтагдах тохиолдол буурсан. - Шүүхийн Тамгын газраас Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсаар мэдээлснээр иргэд олон нийтийн хандалт, талархлыг хүлээсэн байна.	- Үйл ажиллагаагаа төлөвлөж хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, санаачилга гарган ажилладаг хэдий ч төсөв санхүү шаардлагатай зарим ажлуудыг хэрэгжүүлж чаддаггүй, хүндрэл бэрхшээл тулгардаг. - Хорооны гишүүдийн ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн ажлын хажуугаар энэхүү хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарим хүндрэл тулгардаг. Тухайлбал хууль тогтмоож, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байдгаас шалтгаалж, дүгнэлт гаргахад хүндрэл учирдаг. Хариуцлага шаарддаг ч урамшуулал олгогддоггүйгээс Ёс зүйн зөрчил шалгах, дүгнэлт гаргахад эмзэглэх хандлагатай. - Ёс зүйн дэд хороо гомдлыг дүгнэхдээ баримтлах хуулийн заалтыг тодорхой болгох. - Үндсэн ажлын хажуугаар сургалт, нөлөөллийн ажлууд, гомдол шалгах зэрэгт маш их цаг зарцуулж хийж байгаа ч Ёс зүйн дэд хорооны гишүүдэд улирал тутам олгох урамшуулал олгогддоггүй. - Үйл ажиллагаа явуулах төсөв байхгүй. - Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргахдаа айдас, үл итгэлцэлтэй ханддаг байдал. - Ёс зүйн зөрчил шалгах үйл явцад нотлох баримт цуглуулах, бодит үнэлгээ хийхэд хүндрэлтэй байх.

Цахим хуудасны дагагч нэмэгдсэн.	- Ажилтнуудын ёс зүйн талаарх ойлголт, мэдлэг жигд бус, ёс зүйн зөрчлийг анзаарах, мэдээлэх соёл сул байх.

Санал:

1. Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт “ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ”-ын **3.8-д** зааснаар “5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд анхаарах, нэг мөр чиглэл өгч шийдвэрлэх
2. Албан хаагч нарт хууль болон дүрэм журмыг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвөөс олгох
3. Ёс зүйн дэд хорооны гишүүн, нарийн бичгийн даргын урамшууллыг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглохгүй байх, эрх бүхий албан тушаалтан тушаал гаргасан байхад санхүүгийн ажилтан урамшуулал олгохгүй байгааг шийдвэрлэх
4. Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх аюулгүй, нууцлалтай суваг, цахим систем, итгэлцлийн шуудан бий болгох.
5. Мэдээлэгчийг хамгаалах механизмыг тодорхой болгох.
6. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд шаардагдах санхүү, сургалтын дэмжлэг тогтмол үзүүлэх. Улирал тутамд танхимын сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, чиглэл зөвлөмж өгөх.
7. Мэргэжлийн зөвлөх, сургалтын байгууллагатай хамтран ажиллах боломж бүрдүүлэх.
8. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг тогтмол сургалтад хамруулж байх
9. Ёс зүйн хорооноос баталсан дүрэм, журмыг байнга мэдээлж, чиглэл өгч байх
10. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга Д.Мөнхбат

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Б.Нямаа

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2026 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 1-ний өдрийн 9 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.43	4.3
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.42	4.2
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.35	3.5
Хэсгийн оноо				**4**	2.2	22
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд		1	0.78	7.8
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.24	2.4
Хэсгийн оноо				**3**	2.02	20.2
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	0.94	9.4
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл,*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0.87	8.7
Хэсгийн оноо				**3**	2.8	28
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**7**	**70**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга. сэдэв батлах тухай” тогтоол.
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ.
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ж.ДАШДЭМБЭРЭЛ

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.02.17

Д/д	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага, ажилтан	Хамтран ажиллах байгууллага
1.	Шинэ ажилтнуудад зориулсан байгууллагын онцлог, соёл, ажлын байранд мэндлэх, хүндлэх ёс, албаны хувцаслалтын талаарх соён гэгээрүүлэх сургалт	I улиралд	Ёс зүйн дэд хороо	Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо
2.	Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороотой хамтран шүүхийн байгууллагын албан хаагчдад зориулсан Ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	I улиралд	Ёс зүйн дэд хороо	Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо
3.	Ажлын алба болон шүүхийн захиргааны ажилтнуудад “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт зохион байгуулах	III-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
4.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгах	I-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн Тамгын газар
5.	Ажлын албанд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх	III-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
6.	Шийдвэрлэсэн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, шүүхийн Тамгын газарт зөвлөмж, чиглэл хүргүүлэх	II-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба

7.	Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын Ёс зүйн дэд хороодын тайланг улирал, бүтэн жилээр нэгтгэх	Улирал бүр, Бүтэн жил	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн Тамгын газар
8.	Ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Ёс зүйн хороонд хүргүүлэх	Улирал бүр, Бүтэн жил	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
9.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах	III-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
10.	Ес зүйн дэд хорооны зөрчил хянан шийдвэрлэсэн мэдээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст мэдээлэх	III-IY улиралд	Ёс зүйн дэд хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба

-o0o-